ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Баянтүмэн сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДОА-2026/005/НА-СТА-ТТЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2026 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Нармандах<br>Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Батжаргал<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт........................................................................................ 2-3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл......................................................4-6

4. Аудитын илрүүлэлт .........................................................................................................7

5. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.................................................................7

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| НА | Нийцлийн аудит |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг. 21000
Утас: 7058-4203

2026.03.25 № 402

танай__________-ны №__________-т

ДОРНОД АЙМГИЙН
БАЯНТҮМЭН СУМЫН ЗАСАГ
ДАРГА П.ГУНГААЦЭРЭН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Баянтүмэн сумын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 320.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд үйл ажиллагаа явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

1

2126050218

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

2

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

| № | Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| **1** | **1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **1,263,366.41** | **1,783,474.59** |
| **2** | **1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **3а, 3б** | **915,232.06** | **762,504.7** |
| 3 | 1.1.3 АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 149,693.3 | 238,418.2 |
| 4 | 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 195,941.06 | 769,951.7 |
| 5 | 1.1.6 НӨӨЦИЙН БАРАА | 9а | 2,500 | 12,600 |
| 6 | 1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 3,803,687.75 | 3,750,640.68 |
| **7** | **1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **12а, 12б, 12в** | **3,803,687.75** | **3,750,640.68** |
| 8 | 1.2.2.02 Биет хөрөнгө | | 3,598,037.75 | 3,546,370.68 |
| 9 | 1.2.2.03 Биет бус хөрөнгө | 13 | 205,650 | 204,270 |
| **10** | **1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | | **5,067,054.16** | **5,534,115.28** |
| **11** | **2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **-** | **571,333.3** |
| 12 | 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | - | 571,333.3 |
| 13 | 2.1.1.03 Өглөг | | - | 571,333.3 |
| 14 | 2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 5,067,054.16 | 4,962,781.98 |
| 15 | 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | | 5,067,054.16 | 4,962,781.98 |
| 16 | 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | | 695,365.69 | 695,365.69 |
| **17** | **2.2.1.02 Хуримтлагдсан үр дүн** | | **4,138,101.7** | **4,033,829.51** |
| 18 | 2.2.1.03 Өмнөх үеийн үр дүн | | 2,694,540.8 | 4,138,101.7 |
| 19 | 2.2.1.04 Тайлант үеийн үр дүн | | 1,443,560.9 | (104,272.2) |
| 20 | 2.2.1.05 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 233,586.78 | 233,586.78 |
| **21** | **2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | | **5,067,054.16** | **5,534,115.28** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

| № | Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| **1** | **1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | | **5,063,935.96** | **3,455,707.92** |
| **2** | **1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО** | | **2,108,137.22** | **1,170,754.46** |
| 3 | 1.1.1.03.1 Орлогын албан татвар | | 1,215,268.46 | 595,751.02 |
| 4 | 1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар | | 1,264,342.55 | 645,751.02 |
| 5 | 1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | -49,074.09 | -50,000 |
| **6** | **1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар** | | **75,462.27** | **204,588.26** |
| 7 | 1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | | 817,406.48 | 370,415.18 |
| **8** | **1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1а, 1б** | **1,758,447.17** | **2,284,953.46** |
| 9 | 1.1.1.04.3 Тусламжийн орлого | | 204,380.7 | 280,826.79 |
| **10** | **1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **1,197,351.58** | **-** |
| **11** | **1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2а, 2б** | **2,213,733.24** | **1,856,828.12** |
| **12** | **1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ** | | **2,213,733.24** | **1,856,828.12** |
| 13 | 1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 1,892,547.67 | 1,856,828.12 |
| 14 | 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 835,584.79 | 950,119.82 |
| 15 | 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 100,695.26 | 117,987.49 |
| 16 | 1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 112,866.03 | 113,205.07 |
| 17 | 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | | 101,449.03 | 42,348.33 |
| 18 | 1.1.2.01.1.05 Нормативт зардал | | 14,172.63 | 12,328.9 |
| 19 | 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | | 24,924.25 | 3,210.68 |
| 20 | 1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | | 12,791.3 | 7,679 |
| 21 | 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 9,151.55 | 212,098.92 |
| 22 | 1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | | 680,912.84 | 397,849.91 |
| **23** | **1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **321,185.56** | **-** |
| 24 | 1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | | 2,850,202.73 | 1,598,879.8 |
| 25 | 1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 1,406,641.82 | 1,703,151.99 |
| 26 | 1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | | -1,406,641.82 | -1,703,151.99 |
| **27** | **1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)** | | **1,443,560.91** | **-104,272.19** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **3,756,507.37** | **2,575,148.46** |
| **2** | **1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО** | **2,108,137.22** | **1,170,754.46** |
| 3 | 1.1.1.1.03.1 Орлогын албан татвар | 1,215,268.46 | 595,751.02 |
| 4 | 1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -49,074.09 | -50,000 |
| **5** | **1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар** | **75,462.27** | **204,588.26** |
| **6** | **1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж** | **817,406.48** | **370,415.18** |
| 7 | 1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 1,950.2 | 1,446.4 |
| 8 | 1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр | 815,456.28 | 368,968.78 |
| **9** | **1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **451,018.57** | **1,404,393.99** |
| 10 | 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | 246,637.87 | 141,605.12 |
| 11 | 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого | 204,380.7 | 280,826.79 |
| 12 | 1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | - | 981,962.09 |
| **13** | **1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,197,351.58** | **-** |
| **14** | **1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,945,138.51** | **1,509,248.3** |
| **15** | **1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,945,138.51** | **1,509,248.3** |
| 16 | 1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,623,742.95 | 1,509,248.3 |
| 17 | 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 837,126.76 | 950,119.82 |
| 18 | 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 100,695.26 | 117,987.49 |
| 19 | 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 115,868.27 | 113,205.07 |
| 20 | 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 57,853.69 | 29,268.78 |
| 21 | 1.1.1.2.01.1.05 Норматив зардал | 8,281.74 | - |
| 22 | 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 31,804 | 7,983.7 |
| 23 | 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 12,791.3 | 7,679 |
| 24 | 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,371.55 | 212,098.92 |
| 25 | 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 449,950.38 | 70,905.52 |
| **26** | **1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **321,395.56** | **-** |
| **27** | **1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **1,811,368.86** | **1,065,900.16** |
| **28** | **1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **1,501,131.01** | **1,113,627.52** |
| **29** | **1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,501,131.01** | **1,113,627.52** |
| 30 | 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | 1,501,131.01 | 1,113,627.52 |
| 31 | 1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -1,501,131.01 | -1,113,627.52 |
| 32 | 1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | - | 105,000 |
| 33 | 1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | - | -105,000 |
| **34** | **1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **310,237.85** | **-152,727.36** |
| **35** | **1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **604,994.21** | **915,232.06** |
| **36** | **1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **915,232.06** | **762,504.7** |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|---|---|---|
| **1** | **1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,623,076.65** | | **3,623,076.65** |
| 2 | 1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1,037.76 | | 1,037.76 |
| 3 | 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,624,114.41 | | 3,624,114.41 |
| 4 | 1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (621.16) | | (621.16) |
| 5 | 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн | 1,443,560.91 | | 1,443,560.91 |
| **6** | **1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,067,054.16** | | **5,067,054.16** |
| **7** | **1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **5,067,054.16** | | **5,067,054.16** |
| 8 | 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,067,054.16 | | 5,067,054.16 |
| 9 | 1.7 Тайлант үеийн үр дүн | -104,272.19 | | -104,272.19 |
| **10** | **1 2025 оны 12-р сарын 31-нээрх** | **4,962,781.98** | | **4,962,781.98** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Дансны нэр, төрөл | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| **1** | **3.1.01.1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **4,481,735.20** | **4,072,082.01** |
| **11** | **3.1.01.1.1** | **Татварын орлого** | **1,207,585.70** | **1,170,754.46** |
| **110** | **3.1.01.1.1.1** | **Орлогын албан татвар** | **497,023.10** | **595,751.02** |
| 1100 | 3.1.01.1.1.1.1 | Хувь хүний орлогын албан татвар | 547,023.10 | 645,751.02 |
| 1101 | 3.1.01.1.1.1.2 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -50,000.00 | (50,000.00) |
| **113** | **3.1.01.1.1.3** | **Хөрөнгийн албан татвар** | **201,916.00** | **204,588.26** |
| 113001 | 3.1.01.1.1.3.1 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 836.00 | 1,557.16 |
| 113002 | 3.1.01.1.1.3.2 | Бууны албан татвар | 1,080.00 | 1,200.00 |
| 113004 | 3.1.01.1.1.3.4 | Малд ногдуулах албан татвар | 200,000.00 | 201,831.10 |
| **118** | **3.1.01.1.1.8** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | **508,646.60** | **370,415.18** |
| 1180 | 3.1.01.1.1.8.1 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 16,500.00 | 1,446.40 |
| 1181 | 3.1.01.1.1.8.2 | Газрын төлбөр | 492,146.60 | 368,968.78 |
| **12** | **3.1.01.1.2** | **Татварын бус орлого** | **3,274,149.50** | **2,901,327.55** |
| 120 | 3.1.01.1.2.1 | Нийтлэг татварын бус орлого | 99,963.80 | 88,894.42 |
| 122 | 3.1.01.1.2.3 | Тусламжийн орлого | 2,167,045.10 | 1,830,471.05 |
| 123 | 3.1.01.1.2.4 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 1,007,140.60 | 981,962.09 |
| **II** | **3.1.01.2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,549,188.60** | **2,665,752.87** |
| **21** | **3.1.01.2.1** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,460,467.30** | **1,287,493.35** |
| **210** | **3.1.01.2.1.1** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,458,424.40** | **1,287,493.35** |
| 2101 | 3.1.01.2.1.1.1 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 989,952.50 | 948,762.32 |
| 2102 | 3.1.01.2.1.1.2 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 123,743.40 | 117,888.87 |
| 2103 | 3.1.01.2.1.1.3 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 125,975.20 | 113,205.07 |
| 2104 | 3.1.01.2.1.1.4 | Хангамж, бараа материалын зардал | 40,903.00 | 23,668.45 |
| 2106 | 3.1.01.2.1.1.6 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11,412.00 | 7,983.70 |
| 2107 | 3.1.01.2.1.1.7 | Томилолт, зочны зардал | 14,829.70 | 7,679.00 |
| 2108 | 3.1.01.2.1.1.8 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 10,331.80 | 6,745.96 |
| 2109 | 3.1.01.2.1.1.9 | Бараа үйлчилгээний бусад зардал | 141,276.80 | 61,559.97 |
| **213** | **3.1.01.2.1.4** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,042.90** | **-** |
| 2131 | 3.1.01.2.1.4.1 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | - |
| 213103 | 3.1.01.2.1.4.1.03 | Төсвийн санхүүжилт | - | - |
| **2132** | **3.1.01.2.1.4.2** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,042.90** | - |
| 213209 | 3.1.01.2.1.4.2.08 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | **2,042.90** | - |
| **22** | **3.1.01.2.2** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,958,221.30** | **1,273,259.52** |
| 223001 | 3.1.01.2.2.4 | Бусад хөрөнгө | 1,958,221.30 | 1,273,259.52 |
| **23** | **3.1.01.2.3** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **130,500.00** | **105,000.00** |
| 230001 | 3.1.01.2.3.1 | Эргэж төлөгдөх зээл | 130,500.00 | 105,000.00 |
| **8** | **3.1.01** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **932,546.60** | **(154,717.10)** |
| **9** | **3.1** | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-932,546.60** | **154,717.10** |
| 7 | 3 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | -932,546.60 | 154,717.10 |
| **4** | **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | **915,232.06** |
| **5** | **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | **762,504.70** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Дансны нэр, төрөл | | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **1.1.1.1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **16,401.99** |
| **12** | **1.1.1.1.1** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **16,401.99** |
| 122 | 1.1.1.1.1.1 | Тусламжийн орлого | 16,401.99 |
| 1221 | 1.1.1.1.1.1.1 | Хандив тусламж /дотоод/ | 16,401.99 |
| **II** | **1.1.1.2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **16,401.99** |
| **21** | **1.1.1.2.1** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **16,401.99** |
| 210 | 1.1.1.2.1.1 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 16,401.99 |
| 2101 | 1.1.1.2.1.1.1 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,357.50 |
| 210104 | 1.1.1.2.1.1.1.4 | Урамшуулал | 1,357.50 |
| 2102 | 1.1.1.2.1.1.2 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 98.61 |
| 210201 | 1.1.1.2.1.1.2.1 | Тэтгэврийн даатгал | 98.61 |
| 2104 | 1.1.1.2.1.1.4 | Хангамж, бараа материалын зардал | 5,600.33 |
| 210402 | 1.1.1.2.1.1.4.2 | Тээвэр, шатахуун | 5,480.33 |
| 210403 | 1.1.1.2.1.1.4.3 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 120.00 |
| 2109 | 1.1.1.2.1.1.9 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,345.55 |

## 4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 52.8 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулга хийлгэсэн. Үүнд:

Сумын ЗДТГ-ын өмнөх оны санхүүгийн тайланд туссан барилгын сайжруулалт 52.8 сая төгрөгийг тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаагүй орхигдуулсан нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 320,874.7 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Өмнөх оны шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой:**

**1.** *<u>Илрүүлэлт</u>:* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тавигдсан 16.7 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Төлбөрийн актыг барагдуулж ажиллах зөвлөмж өгөв. (Захиргааны ерөнхий хуулийн 83 дугаар зүйлд заасны дагуу 90 хоногийн дотор төлбөрийн актыг барагдуулах тухай мэдэгдэх хуудас өгсөн.)

**Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой:**

**2.** *<u>Илрүүлэлт</u>:* Шилэн дансны цахим хуудсанд ТТЗ-ийн байршуулбал зохих 179 мэдээллээс 174 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж, 5 мэдээллийг хуулийн хугацаа хоцроон байршуулсан байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж ажиллах зөвлөмж өгөв.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хамрах хүрээний байгууллагын тайланг зөрүүтэй нэгтгэсэн | 1 | 52.8 | 1 | 52.8 | - | - | 1 | 52.8 | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **52.8** | **1** | **52.8** | **-** | **-** | **1** | **52.8** | **-** | **-** | **-** | **-** |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Акт барагдуулаагүй | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| Шилэн данс хугацаа хоцроосон. | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| **Нийт дүн** | **2** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **2** | **-** |